



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 36 95, Факс: (976-11) 32 35 41
Цахим шуудан: letter@moh.gov.mn
Цахим хуудас: www.moh.gov.mn

2025. 11. 24 № 4/5576

танай _____-ны № _____-т


АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ТӨВ
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ, ЭРҮҮЛ
МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын
10-ны өдрийн 379 дүгээр тушаалаар батлагдсан Эрүүл
мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих арга
хэмжээ (2025-2028)-ний төлөвлөгөөг хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт: 16 хуудастай.

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ТУЯА



146251234



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/379

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн
хөгжлийг дэмжих арга хэмжээний
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8, 8.1.9, 8.1.10 дах заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих арга хэмжээ (2025-2028 он)-ний төлөвлөгөөг нэгдүгээр, шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, бодлогын зохицуулалтаар ханган ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар (Б.Туяа)-т, шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгуулж, санхүүжүүлж ажиллахыг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газар (Л.Мөнхцэцэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, харьяалах эрүүл мэндийн байгууллагын тайланг нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Бодлого төлөвлөлтийн газарт ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, бусад холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

5. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөв, хамтын ажиллагаатай улс орон болон олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж, үр дүнг тайлагнаж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141252237

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ
(2025-2028 он)

Нэг. Нийтлэг үндэслэл

Эрүүл мэндийн салбарын эрхэм зорилго нь хүн амд эрүүл мэндийн үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чанартай үзүүлэхэд чиглэдэг бөгөөд гол хөдөлгөгч хүч нь эрүүл мэндийн ажилтнууд байдаг.

Эрүүл мэндийн ажилтны ажил үүргийн зөв хуваарилалт, хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн өсөлт хөгжил, ажлын сэтгэл ханамж, эерэг хандлага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, чанар, гүйцэтгэлд шууд нөлөөлөх тул эрүүл мэндийн ажилтнуудыг тогтвортой ажлын байраар хангах нь нэн чухал болохыг ДЭМБ-аас онцолсон байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 2023 оны "Үнэ цэн бүхий ажил, мэргэжлийн тайлан"-д эрүүл мэндийн мэргэжил нь найман чухал ажлын нэг болохыг тодорхойлсон байдаг. Гэсэн хэдий ч эрүүл мэндийн ажилтнуудад биет болон биологийн аюул, нийгэм-сэтгэл зүйн эрсдэл тулгарахаас гадна цалин багатай, уртасгасан болон тогтмол бус цагаар ажиллах зэрэг нь тэрхүү үнэ цэнийг бууруулж байгааг дурджээ. Үүний зэрэгцээ коронавируст халдвар (КОВИД-19)-ын дараах өнөөгийн нөхцөлд эрүүл мэндийн ажилтнуудыг эргэн татах, хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажиллуулах сорилттой дэлхийн улс орнууд нүүр тулж байна.

Мөн халдварт болон халдварт бус өвчний тархалт, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, хүн амын насжилт, анагаах ухааны технологийн хурдацтай хөгжлийг даган өсөн нэмэгдэж байгаа эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг хангахад эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжил боловсрол, мэргэшлийн ур чадвар, хүчин чармайлт, үүрэг хариуцлага нэмэгдсээр байна. Үүнтэй уялдан эрүүл мэндийн ажилтны ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, тэдний ажлын байрыг баталгаатай болгож, тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, дэмжих нь нэн чухал асуудал болж байна.

Түүнчлэн Эрүүл мэндийн хүний нөөцийн дэлхийн стратегид эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүний нөөцийн үр дүнтэй бодлогыг хэрэгжүүлэн эрүүл мэндийн ажиллах хүчний хүрэлцээ, хүртээмж, хүлээн зөвшөөрөгдөх байдал болон чанарыг сайжруулснаар бүх нийтийн эрүүл мэндийн хамралт, тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх болохыг тодорхойлсон.

Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчинд хөрөнгө оруулалт хийх нь улс орны нийгэм-эдийн засагт ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ дэх хөдөлмөр эрхлэлт нь бусад салбартаа өсөлтийг бий болгох тул аль ч улс орны хувьд анагаах ухаан боловсрол, эрүүл мэндийн хөдөлмөрийн зах зээлд хөрөнгө оруулах нь мэргэшсэн ажлын байрыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн зах зээлийг тэлдэг байна.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах, хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний зохион байгуулалт төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийг бэлтгэж, орон нутгийн хэрэгцээг хангах асуудлыг онцлон авч үзсэн.

Иймээс өргөн уудам нутаг дэвсгэртэй, зарим аймаг, сум төвөөс алслагдсан, хүний нөөц харьцангуй бага, эрүүл мэндийн салбарын ажиллагчдын 80 гаруй хувь нь эмэгтэй байдаг манай орны хувьд хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай хүргэхийн тулд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн цогц бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Энэ хүрээнд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбар хоорондын хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх, эмч мэргэжилтнийг бэлтгэх, тасралтгүй сургаж мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэхэд чиглэсэн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих арга хэмжээ (2025-2028)-ний төлөвлөгөөг боловсрууллаа.

Хоёр. Арга хэмжээний зорилго, зорилт

2.1 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог салбарын хэрэгцээтэй уялдуулан, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй төлөвшил, нийгмийн баталгааг сайжруулна.

2.2 Арга хэмжээний хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1 Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хэрэгцээтэй уялдуулах;

2.2.2 Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийг дэмжиж, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх;

2.2.3 Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах дэмжлэгт орчныг сайжруулж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;

2.2.4 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хандлагыг сайжруулах;

Гурав. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим

3.1 Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1 эрүүл мэндийн салбарын тогтвортой бодлого, мэргэжлийн удирдлагыг бэхжүүлэх;

3.1.2 хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиг хандлага, тэргүүлэх зорилтод нийцсэн байх;

3.1.3 эрүүл мэндийн ажилтны хувийн, хөдөлмөрлөх, мэргэжлийн эрхийг хамгаалсан байх;

3.1.4 гэр бүл, иргэн, төр, олон нийтийн хамтын оролцоо, үүрэг хариуцлагыг бэхжүүлэх, дэмжих;

3.1.7 нотолгоонд суурилсан, инновацийг дэмжсэн, үр дүнтэй нь тогтоогдсон баримт мэдээлэл ашиглах.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа

4.1 Арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

4.2 Арга хэмжээний хэрэгжилтийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.3 Арга хэмжээг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, түүний холбогдох нэгж нь бусад төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж болно.

Тав. Арга хэмжээний санхүүжилт

5.1 Арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллагуудын санхүүжүүлэх арга хэмжээний уялдаа холбоог сайжруулах, төсвөөс болон олон улсын байгууллага, бусад эх үүсвэрүүдээс орсон хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарна. Шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 5.1.1 улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2 гадаадын зээл, буцалтгүй тусламж;
- 5.1.3 олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 5.1.4 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;
- 5.1.5 хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Арга хэмжээний үр дүн

6.1 Арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

6.1.1 Салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагаа сайжирч, орон нутгийн удирдлагын оролцоо нэмэгдэж, удирдах албан тушаалтны манлайллын чадавхи, хүний нөөцийн мэдлэг, ур чадвар дээшилсэн байна;

6.1.2 Анагаах ухааны боловсрол олгох сургуулиудын элсэлт хүний нөөцийн хэрэгцээтэй уялдаж, зорилтот элсэлт авдаг практик тогтсон байна;

6.1.3 Эмч, мэргэжилтний тасралтгүй хөгжлийн тогтолцоо бэхжиж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлал бүрт тохирсон ур чадварын болон байршлын зохистой харьцаа бүрдсэн байна;

6.1.4. Хүний нөөцийн хөгжлийг дэмжих бодлого, төлөвлөлтөд ашиглах бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоо нэвтэрч, байгууллагын түвшинд оновчтой төлөвлөлт хийх чадавхи бүрдсэн байна;

6.1.5 Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын нийгмийн баталгаа хангагдаж, ажиллах эрмэлзлэлийг нэмэгдүүлэх дэмжлэгт орчин бүрдэж, урамшууллын удирдлагын тогтолцоо төлөвшсөн байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ /2025-2028/-НИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог салбарын хэрэгцээтэй уялдуулан, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй төлөвшил, нийгмийн баталгааг сайжруулах.

Зорилт:

- 1. Эрүүл мэндийн ажилтан бэлтгэх тогтолцоог эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хэрэгцээтэй уялдуулах
- 2. Эрүүл мэндийн ажилтны хөгжлийг дэмжих, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх
- 3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах дэмжлэг орчныг сайжруулж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- 4. Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, хандлагыг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Эх үүсвэр Нийт хөрөн- гийн хэмжээ (сая. төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн сая төг								Үндсэн	Хамтрагч
				2025		2026		2027		2028			
				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая. төг	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая. төг	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая. төг	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая. төг		
Зорилт 1. Эрүүл мэндийн ажилтан бэлтгэх тогтолцоог эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хэрэгцээтэй уялдуулах													
Үйл ажиллагааны чиглэл 1.1 Төсөлийн өмнөх сургалтын чанарыг сайжруулж, эрүүл мэндийн салбарын эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэдлэг, чадвар, хандлагата бүхий эрүүл мэндийн ажилтныг бэлтгэх													
1.1.1 Эрүүл мэндийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний шаардлагад нийцүүлэн сайжруулах	Улсын төсөв гадаадын зээл тусламж 130.0	Хөтөлбөрийн шинэчлэл, хувь	-	20	20.0	30	30.0	40	40.0	50	40.0	БЯ, ЭМЯ	Анагаах ухааны сургуулиуд
1.1.2 Эрүүл мэнд, анагаахын чиглэлээр сургалт эрхэлдэг байгууллагын матадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг нэмэгдүүлэх	Байгууллагын төсөв эрхэлдэг 7,500.0	Матадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр, өссөн тоо	35	38	1,500.0	42	2,000.0	46	2,000.0	50	2,000.0	БЯ, ЭМЯ	БМИУЗ ЭМ, анагаахын чиглэлээр сургалт эрхэлдэг байгууллагууд
1.1.3 Анагаахын боловсрол олгох мэргэжлийн чиглэл, индексийг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх	Улсын төсөв	Хүргүүлсэн санал, арга хэмжээний тоо	-	1	-	2	-	-	-	-	-	ЭМЯ, БЯ	Эрүүл мэнд, анагаахын чиглэлээр сургалт эрхэлдэг байгууллагууд
1.1.4 Шинэ төгссөн эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын эрх зүйн орчныг шинэчлэх	Улсын төсөв	Боловсруулах журал, тоо	ЭМС-ын 2023 оны А/295 тушаал	1	-	-	-	-	-	-	-	ЭМЯ, ЭМХТ	Эрүүл мэнд, анагаахын чиглэлээр сургалт эрхэлдэг байгууллагууд

1.1.5 Шинэ сувилалч, эх баригчийг ажилын байранд мэргэжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	Улсын төсөв, Харчуулах байгууллагын төсөв, Гадаадын зээл тусламж 120.0	Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн эрүүл мэндийн байгууллага, тоо	2	4	30.0	8	30.0	12	30.0	16	30.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
1.1.6 Нийгмийн эрүүл мэндийн сувилалч бэлтгэх	Улсын төсөв, Харчуулах байгууллагын төсөв, Гадаадын зээл тусламж 60.0	Бакалаврын хөтөлбөрөөр эрүүл мэндийн нийгмийн эрүүл мэндийн сувилалч, тоо	3 сарын төрөлжсөн өн мэргэжл ийн сургалта ар бэлтгэгдсэн сувилалч 8	20	30.0	40	10.0	60	10.0	80	10.0	ЭМЯ, БЯ	БЯ, АШУУИС, Эрүүл мэнд, ангаахын чиглэлээр сургалт эрхэлдэг байгууллагууд
1.1.7 Сувиллахуйн чиглэлээр суралцаж буй оюутныг суралцанаа туслах сувилалчаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.	Улсын төсөв, Харчуулах байгууллагын төсөв	Боловсруулах журам, тоо	-	1	-	-	-	-	-	-	-	ЭМЯ, БЯ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМБ
1.1.8 Эрүүл мэндийн байгууллагад ажиллах олон нийтийн эрүүл мэндийн ажигтан бэлтгэх	Улсын төсөв, Харчуулах байгууллагын төсөв, Гадаадын зээл тусламж 80.0	Олон нийтийн эрүүл мэндийн ажигтан, тоо	45	80	20.0	80	20.0	80	20.0	80	20.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
Үйл ажиллагааны чиглэл 1.2 Нэн шаардлагатай мэргэшилээр эрүүл мэндийн ажигтан бэлтгэх, орон нутгийг эмнэлгийн мэргэжилтнээр хангах чиглэлээр хүний нөөцийг сургах													
арга хэмжээг хэрэгжүүлэх													
1.2.1 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ирэх 5 жилийн хэрэгцээг судалж, төлөвлөлт хийх	Улсын төсөв Олон улсын төсөв, хөтөлбөр	5 жилийн хэрэгцээний судалгаа, төлөвлөлт	-	1	20.0	-	-	-	-	-	-	ЭМЯ, ЭМХТ АШУУИС	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймаг, нийслэлийн ЭМГ
1.2.2 Нэн шаардлагатай мэргэшилээр эрүүл мэндийн ажигтан бэлтгэх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, байгууллагын төсөв 30.0	Төрөлжсөн мэргэшлийн эмчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, тоо	-	1	20.0	-	-	-	-	-	-	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймаг, нийслэлийн ЭМГ
1.2.3 Орон нутгийн захиалгаар элсэх төрөлжсөн мэргэшлийн сургалтын элсэлтийн тоог	Улсын төсөв, Орон нутгийн төсөв,	Төрөлжсөн мэргэшлийн сургалтад улсын төсвийн	178	325	400.0	340	420.0	355	440.0	360	460.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд

тэргүүлэх өвчнөлд тулгуурлан төрөлжүүлэх, нэмэгдүүлэх	байгууллагын төсөв 1,720.0	санхүүжилтээр суралцуулах эмч мэргэжилтний тоо																		Б.Я. Аймал, нийслэлийн ЭМГ
1.2.4 Сувилагч, туслах сувилагчдыг бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Улсын төсөв 10,255.0	Бэлтгэгдэх сувилагч, тоо	580	650	2,380.0	750	2,625.0	750	2,625.0	750	2,625.0	ЭМЯ	Аймгийн ЗДТГ, ЭМГ							
1.2.6 Орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлт хийх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Байгууллагын төсөв 190.0	Хүний нөөцийн төлөвлөлт хийсэн аймаг, өссөн тоо	-	2	10.0	7	35.0	12	60.0	17	85.0	ЭМЯ, ЭМХТ	Аймгийн ЗДТГ, ЭМГ							
1.2.7 Эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх	Гадаадын зээл тусламж 200.0	Судалгааны тайлан	-	1	200.0	-	-	-	-	-	-	ЭМЯ, ЭМХТ	ДЭМБ, МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, эрүүл мэндийн байгууллагууд							

Үйл ажиллагааны чиглэл 1.3 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнийг ажлын байран дээр мэргэшүүлж бэлтгэх

1.3.1 Орон нутагт Ерөнхий мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагын тоог нэмэгдүүлж, сургалт эрхлэх чадавхийг бэхжүүлэх	Улсын төсөв, орон нутгийн төсөв, байгууллагын төсөв 1,400.0	Сургалт эрхлэх байгууллага, өссөн тоо	7	10	300.0	15	500.0	21	600.0	-	-	ЭМХТ	Аймгийн ЗДТГ, ЭМГ
1.3.2 Аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийг сургалт эрхлэх байгууллага болгож, сургалтыг хэрэгжүүлэх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Байгууллагын төсөв 1,600.0	Сургалт эрхлэх аймгийн нэгдсэн эмнэлэг, тоо	2	2	200.0	3	300.0	4	400.0	5	500.0	ЭМХТ	Аймгийн ЗДТГ, ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
		Сургалтад хамрагдсан эмнэлгийн тоо	32	32	50.0	48	50.0	64	50.0	80	50.0		

Үйл ажиллагааны чиглэл 1.4 Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчдад ангаах ухааны чиглэлээр ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох

1.4.1 Ахлах ангийн суралцагчдад ангаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Гадаадын зээл тусламж 800.0	Сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан 9-12 дугаар ангийн суралцагчдын зэлэх хувь	5	20	100.0	30	100.0	40	100.0	50	100.0	ЭМЯ, ЭМХТ	Б.Я. Аймал, нийслэлийн ЗДТГ, аймал, нийслэлийн ЭМГ
		Төрөлжсөн ахлах сургууль, тоо	4	1	100.0	1	100.0	1	100.0	1	100.0	ЭМЯ, Б.Я	Аймал, нийслэлийн ЗДТГ, аймал, нийслэлийн ЭМГ

Зорилт 2. Эрүүл мэндийн ажилтны хөтөлжийг дэмжиж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх

Үйл ажиллагааны чиглэл 2.1 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд бусад салбар, орон нутаг болон оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх

2.1.1 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн асуудлаарх салбар хоорондын зохицуулалт бий болгох	Улсын төсөв 20.0	Урлагт хэлэлцүүлэг, тоо	-	2	5.0	2	5.0	2	5.0	2	5.0	ЭМЯ, ЭМХТ	Б.Я. ГЕХНЯ
2.1.2 Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, хүний нөөцийн ажиглалтын зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулах	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж 320.0	Зөвлөгөөний тайлан, зөвлөмж	1	1	80.0	1	80.0	1	80.0	1	80.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд
2.1.3 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн удирдлагыг бэхжүүлэхэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх	Орон нутгийн төсөв 200.0	Нөлөөллийн үйл ажиллагаа, тоо	-	5	50.0	12	50.0	17	50.0	21	50.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭЛПГ, ЭМГ
2.1.4 Эрүүл мэндийн ажилтныг тасралтгүй хөгжүүлэхэд мэргэжлийн нийгэмлэг, холбоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж 200.0	Зохион байгуулсан сургалт, семинарын тоо	-	10	50.0	15	50.0	20	50.0	25	50.0	ЭМЯ, ЭМХТ	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо
2.1.5 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцооны нөхцөл байдлын үнэлгээ хийх	Гадаадын зээл тусламж 100.0	Түрэгчилсэн үнэлгээний тайлан	-	1	100.0	-	-	-	-	-	-	ЭМЯ, ЭМХТ	Б.Я.
2.1.6 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	Гадаадын зээл тусламж 400.0	Зохион байгуулсан хурлын тоо	-	1	100.0	1	100.0	1	100.0	1	100.0	ЭМЯ, ЭМХТ	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ДЭМБ

Үйл ажиллагааны чиглэл 2.2. Эмнэлгийн мэргэжлтийн төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын тогтолцоог бэхжүүлэх

2.2.1 Төгсөлтийн дараах сургалтын журмыг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хариуцах байгууллагын төсөв 80.0	Боловсруулах журам, тоо	ЭМС-ын 2017 оны А/337 тушаал	1	-	-	-	-	-	-	-	ЭМЯ, ЭМХТ	МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ, Аймаг, нийслэлийн ЭМГ
2.2.2 Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийг шинэчлэн боловсруулах	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хариуцах байгууллагын төсөв 80.0	Боловсруулах журам, тоо	2021 оны А/445 тушаал	1	-	-	-	-	-	-	-	ЭМЯ, ЭМХТ	МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ
2.2.3 Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг үнэлж, тогтмол сайжруулах	Улсын төсөв 200.0	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээний тайлан, тоо	-	1	50.0	1	50.0	1	50.0	1	50.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ

2.2.4	Эмнэлгийн мэргэжилтний мэргэшүүлэх болон давтан сургалтын цөм хөтөлбөрийг үнэлэх, шинэчлэх	Улсын төсөв, Хариуцах байгууллагын төсөв 24.0	Шинэчлэгдсэн сургалтын хөтөлбөр, тоо	2	4	6.0	6	6.0	8	6.0	10	6.0	ЭМХТ	МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ, ДЭМБ
2.2.5	Улсын төсвийн хөрөнгөөр төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч нарын ажлын үр дүнг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог нэвтрүүлэх	Улсын төсөв 60.0	Батлагдсан арчааллын хэрэгжилт, хувь	-	30	15.0	50	15.0	70	15.0	90	15.0	ЭМХТ	МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ
2.2.6	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдасдын мэдлэг, үр чадварыг сорих уралдаан тэмцээн, хэлэлцүүлэг зохион байгуулах	Улсын төсөв, Хариуцах байгууллагын төсөв 80.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2	2	20.0	2	20.0	2	20.0	2	20.0	ЭМХТ	МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ
2.2.7	Эмнэл зүйн сургалч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, эмнэлзүйн сургалч бэлтгэх бэлтгэх	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж 400.0	Хөтөлбөрийн шинэчлэл, хувь Бэлтгэгдсэн сургалч бэлтг., тоо	-	30.0	30.0	50.0	30.0	70.0	30.0	100.0	30.0	ЭМХТ	МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ
Үйл ажиллагааны чиглэл 2.3 Эрүүл мэндийн ажиглалтыг үр чадвараа тасралтгүй хөгжүүлэх нөхцөлийг сайжруулах														
2.3.1	Эрүүл мэндийн ажиглалтыг зайн сургалтыг өргөжүүлж, эмнэл зүйн үр чадварыг нэмэгдүүлэх	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж 400.0	Хэрэгжилт, хувь	-	70	100.0	80	100.0	85	100.0	90	100.0	ЭМЯ, ЭМХТ	МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ
2.3.2	Ажлын байран дахь төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж 2,000.0	Батлагдсан сургалтын хөтөлбөр Хамрагдсан мэргэжилтэн, өссөн тоо	-		500.0		500.0	80		90	500.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМЯ, Эрүүл мэндийн байгууллагууд
2.3.3	Эмч, сувилагч мэргэжлийн үр чадвараа тасралтгүй дээшлүүлэх нөхцөлийг сайжруулах	Улсын төсөв 10,600.0	Цахим сургалтад хамрагдлт, хувь	50	5	500.0	10	600.0	20	700.0	30	800.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМЯ, Эрүүл мэндийн байгууллагууд, МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ
			Олон улсын гэрчилгээтэй сургалтад хамрагдсан Эрүүл мэндийн ажиглалт, хувь Симуляцийн сургалтад 10 аас дээш цаг хамрагдсан Эрүүл мэндийн ажиглалт, хувь	-	10	1,000.0	10	1,000.0	10	1,000.0	10	1,000.0		
2.3.4	Эрүүл мэндийн салбарын бусад ажиглалтыг чадавхыг сайжруулах (жолооч, үйлчилгээний ажиглан)	Улсын төсөв 20.0 Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан сургалт, семинарын тоо	-	50	50.0	100	50.0	150	50.0	200	50.0	Бүх шатны ЭМБ	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо

2.3.5	Нээлттэй, цахим, онлайн, зайн сургалтын агуулга, нөөц хэрэглэдэггүйн чанарыг баталгаажуулж, бүртгэлжүүлэх	Улсын төсөв, гадаадын зээл тусламж 100.0	Баталгаажих бүртгэсэн сургалт хувь	-	10	25.0	20	25.0	30	25.0	40	25.0	ЭМЯ, ЭМХТ	МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ
2.3.6	Цахим сургалтын нэгдсэн платформ, өргөжүүлж, цахим хичээлийн сан бүрдүүлэх	Улсын төсөв 6,000.0	Цахим платформын хөгжүүлэлт, хувь	-	30	1,000.0	50	1,000.0	70	1,000.0	90	4,500.0	ЭМЯ, ЭМХТ	МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ
2.3.7	Эрүүл мэндийн ажиглалтанд мэргэжлийн зэрэг олгох эрх зүйн орчныг шинэчлэх	Улсын төсөв	Боловсруулах журам, тоо	ЭМС-ын 2019 оны А/513 тушаал	1	-	-	-	-	-	-	-	ЭМХТ	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ, эрүүл мэндийн байгууллагууд
2.3.8	Эмнэлтийн мэргэжилтний мэргэжлийн үр чадварын ахиц, дэвшилийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, хэрэгжүүлэх	Улсын төсөв, гадаадын зээл тусламж 500.0	Мэргэжлийн чиглэлээр шалгуур үзүүлэлт боловсруулах, тоо	Засгийн газрын 219 тогтоол	2	125.0	3	125.0	4	125.0	5	500.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
2.3.9	Эмнэлтийн мэргэжилтний карьерын замын зурталыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх	Улсын төсөв, Хармундах байгууллагын төсөв, гадаадын зээл тусламж 1,200.0	Боловсруулах карьерын зуртал, хувь	-	20	-	30	-	40	-	50	-	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
2.3.10	Эрүүл мэндийн салбарын ажиглалт, албан хаагчдын албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг шинэчлэн батлуулах	Улсын төсөв, гадаадын зээл тусламж 200.0	Албан тушаалын тодорхойлолтын шинэчлэл, хувь	10	10	50.0	10	50.0	10	50.0	10	50.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
2.3.11	Эмнэлтийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалт авах сорилтын чанарыг үнэлж, шинэчлэх	Улсын төсөв, гадаадын зээл тусламж 200.0	Сорилтын шинэчлэл, хувь	-	30	50.0	50	50.0	70	50.0	90	50.0	ЭМЯ, ЭМХТ	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ
Үйл ажиллагааны чиглэл 2.4 Эрүүл мэндийн ажиглалтын өндөр хөгжилтэй улс орнуудад сургаж, үр чадварыг нэмэгдүүлэх, гадаад улсад бэлтгэгдсэн эмч, мэргэжилтэн өөрийн мэдлэг, туршлагаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжих														
2.4.1	Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2025-2028 оны тэргүүлэх чиглэлийг батлан хэрэгжүүлэх	Улсын төсөв, гадаадын зээл тусламж 2,400.0	Батлуулах тушаал, тоо	ЭМС-ын 2022 оны А/185 тушаал	1	-	-	-	-	-	-	-	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
			Урт хугацааны сургалтад	20	20	500.0	20	500.0	20	500.0	20	500.0	ЭМЯ, СЯ БЯ	

2.4.2	Эмч, мэргэжилтнийг гадаад улсад урт, богино хугацааны сургалтад багтаар нь хамруулах	Улсын төсөв, Хариуцах байгууллагын төсөв, гадаадын зээл тусламж 5,000.0	Хамрагдах эмч мэргэжилтэн, тоо															ЭМХТ, Аймгаг, нийслэлийн ЭМГ
			Богино хугацааны сургалтад хамрагдах эмч мэргэжилтэн, тоо	200	200	300.0	200	300.0	200	300.0	200	300.0						
2.4.3	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад улс орнуудад төгсөлтийн дараах резидентийн сургалтад хамруулах	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж 5,200.0	Суралцах баг, тоо	-	12	2,000.0	5	1,000.0	5	1,000.0	5	1,000.0						СЯ, БЯ, Аймгаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
			Резидентийн сургалтад хамрагдсан эмч, өссөн тоо	-	2	-	4	1,200.0	6	1,600.0	8	2,400.0						Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
2.4.4	Гадаад улс орны эрүүл мэндийн байгууллага хооронд эмч мэргэжилтний солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	Улсын төсөв, Хариуцах байгууллагын төсөв, гадаадын зээл тусламж 5,000.0	Солилцооны хөтөлбөр, тоо	-	2	1,250.0	2	1,250.0	2	1,250.0	2	1,250.0						Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
			Зочин, профессор, эмч мэргэжилтэн, тоо	-	10	100.0	10	100.0	10	200.0	10	200.0						Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
2.4.5	Эрүүл мэндийн байгууллагуудад гадаадын нэр хүнд бүхий эмч мэргэжилтнийг урьж ажиллуулах, ажлын байрны сургалт аялуулах	Улсын төсөв, Хариуцах байгууллагын төсөв, гадаадын зээл тусламж 800.0	Ажлын байрны сургалтад хамрагдах эмч мэргэжилтэн, тоо	-	200	100.0	200	100.0	200	100.0	200	100.0						Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
			Хурал, уулзалт, зөвлөгөөн, тоо	-	2	250.0	3	250.0	4	250.0	5	250.0						Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
Үйл ажиллагааны чиглэл 2.5 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, чадавхийг бэхжүүлэх, тасралтгүй хөгжих тогтолцоо бүрдүүлэх																		
2.5.1	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээ үзүүлэх хүний нөөцийн чиг үүрэг, үзүүлэх тусламж үйлчилгээг тодорхойлох	ДЭМБ, Цэргэхлын сан 52.0	Чиг үүрэг, үзүүлэх тусламж үйлчилгээг тодорхойлсон байдал, хувь	-	50	30.0	100	22.0	-	-	-	-						ЭМХТ, МСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ДЭМБ

2.5.2 Нийгмийн эрүүл мэндийн үндсэн тусламж үйлчилгээг хүргэх мэргэжилтнүүдийн эзэмшвэл зохих үр чадвар, чадавхийг тодорхойлж, ажлын байранд тавигдах шаардлагыг шинэчлэх	ДЭМБ, Цартахлын Сан 39.0	Боловсруулах ажлын байрны тодорхойлолт, хувь	-	50	39.0	100	-	-	-	-	-	-	-	ЭМХТ, ХӨСҮТ	НЭМТ, АШУУИС, МСЗ Мэргэжлийн нийгэмлэг холбоо, ДЭМБ
2.5.3 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээ, тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн дайчилгааны журам боловсруулах	Улсын төсөв, ДЭМБ 0.8	Боловсруулах журам, тоо	1	0.8	-	-	-	-	-	-	-	-	-	ЭМЯ	ХӨСҮТ, МЭЕГ, БОАЖЯ, ХХААХҮЯ, НЭМТ, ЦЭКАА, ОБЕГ, ДЭМБ
2.5.4 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр явагдаж буй төсөлтийн дараах сургалтын цөм хөтөлбөрт үнэлгээ хийж, цөм хөтөлбөрийг шинэчлэх	Улсын төсөв, ДЭМБ 100.0	Хөтөлбөрийн шинэчлэл, хувь	-	50	50.0	100	50.0	-	-	-	-	-	-	ЭМХТ, ЭМЯ	Мэргэжлийн нийгэмлэг холбоо, АШУУИС, ДЭМБ
2.5.5 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах мэргэжилтнүүдэд зориулсан богино хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах	Улсын төсөв, ДЭМБ 280.0	Боловсруулах сургалтын хөтөлбөр, тоо	-	4	10.0	4	10.0	4	10.0	4	10.0	4	10.0	ЭМХТ	ХӨСҮТ, МЭЕГ, БОАЖЯ, ХХААХҮЯ, НЭМТ, ЦЭКАА, ОБЕГ, ДЭМБ
2.5.6 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах мэргэжилтнийг чадавхижуулах сацбар хоорондын дасгал сургуулилт зохион байгуулах	Улсын төсөв, ДЭМБ 900.0	Зохион байгуулсан дасгал сургуулилт, тоо	-	2	100.0	4	200.0	4	200.0	4	200.0	4	200.0	ЭМЯ	ХӨСҮТ, МЭЕГ, БОАЖЯ, ХХААХҮЯ, НЭМТ, ЦЭКАА, ОБЕГ, ДЭМБ
2.5.7 Тапбарын тархвар судлалын төрөлжсөн мэргэшлийн сургалтыг зохион байгуулах	Улсын төсөв 25.0	Сургалтад хамрагдсан мэргэжилтэн, тоо	105	113	6,25.0	121	6,25.0	129	6,25.0	137	6,25.0	-	-	ЭМХТ, ХӨСҮТ	ХӨСҮТ, НЭМТ, МЭЕГ, ДЭМБ
2.5.8 Анхан шатны Тапбарын тархвар судлал мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах	Улсын төсөв, ДЭМБ/Цар тахлын сан 400.0	Сургалтад хамрагдсан мэргэжилтэн, тоо	80	110	100.0	140	100.0	170	100.0	200	100.0	-	-	ЭМХТ, ХӨСҮТ	ХӨСҮТ, МЭЕГ, БОАЖЯ, ХХААХҮЯ, НЭМТ, ЦЭКАА, ОБЕГ, ДЭМБ
2.5.9 Тапбарын тархвар судлал-Лаборатори төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх сургалтын цөм хөтөлбөр батлуулсан, мэргэжлийн индекс авах, сургалтыг зохион байгуулах	ДЭМБ/Цар тахлын сан 20.0	Сургалтад хамрагдсан мэргэжилтэн, тоо	-	10	5.0	20	5.0	30	5.0	40	5.0	-	-	ЭМХТ, ХӨСҮТ	ХӨСҮТ, НЭМТ, МЭЕГ, ДЭМБ

2.5.10 Нийгмийн эрүүл мэндийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Гадаадын зээл тусламж, Глобал сан 6,000.0	Боловсруулах хөтөлбөр, тоо	-	1,500.0	6	1,500.0	6	1,500.0	6	ЗМЯ, ЭМХТ	НЭМҮТ, АШУУИС, аймаг, нийслэлийн ЗМГ		
Зорилт 3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах дэмжлэгт орчин сайжруулах													
Үйл ажиллагааны чиглэл 3.1 Эрүүл мэндийн ажилтны аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийг нь хамгаалах													
3.1.1 Эрүүл мэндийн ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг холбогдох талуудтай хамтран үнэлж, шинэчлэх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Харууцах байгууллагын төсөв	Гэрээний шинэчлэл, хувиар	-	80	50.0	90	50.0	65	50.0	100	50.0	ЗМЯ, ЭСХЭХ, ГБХНХЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
3.1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлийн сургалт, сурталчилгааг эрүүл мэндийн ажилтнуудад зохион байгуулах	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Харууцах байгууллагын төсөв	Зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо	-	10	50.0	10	50.0	10	50.0	10	50.0	ЗМЯ, ГБХНХЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
3.1.3 Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн ажилтныг шаардлага хангасан нэгдсэн загвар бүхий ажлын хувцас, ажлын хэрэгсэлээр бүрэн хангаж, тогтмол хугацаанд шинэчлэх	Харууцах байгууллагын төсөв	Дүрэмт хувцас, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр хангагдсан эрүүл мэндийн ажилтан, хувиар	-	1000	-	2000	3000	-	4000	-	-	ЗМЯ, ГБХНХЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
3.1.4 Эрүүл мэндийг дэмжих эрүүл мэндийн байгууллага хөдөлгөөн өрнүүлэх	Улсын төсөв, Харууцах байгууллагын төсөв, Гадаадын зээл тусламж 20.0	Эрүүл мэндийг дэмжих байгууллагын тоо	-	3	5.0	3	5.0	3	5.0	3	5.0	ЗМЯ, ГБХНХЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
Үйл ажиллагааны чиглэл 3.2 Санхүүгийн болон санхүүгийн бүс урамшууллын шинэ аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн ажилтны бодит орлогыг нэмэгдүүлэх													
3.2.1 Эрүүл мэндийн ажилтны орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг холбогдох яам, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Орон нутгийн төсөв, Харууцах байгууллагын төсөв	Орон сууцны нөхцөлөө сайжруулах ажилтан, тоо	-	10	500.0	10	500.0	10	500.0	10	500.0	ЗМЯ, СЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
3.2.2 Эрүүл мэндийн ажилтнуудыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах чиглэлээр банкуудтай хамтран ажиллах	Байгууллагын төсөв	Ипотекийн зээлд хамрагдсан ажилтан, тоо	1233	1300	-	1300	-	1300	-	1300	-	ЗМЯ, СЯ	Арижгааны банк, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
3.2.3 Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгаалын хөтөлбөрийн	Орон нутгийн төсөв	Нийгмийн хамгааллын	-	5	50.0	8	50.0	10	50.0	15	50.0	ЗМЯ, аймаг	Аймаг, нийслэлийн

хэрэгжилтэд орон нутгийн захирагчааны болон эрүүл мэндийн байгууллага, бусад салбар, хувийн хэвшлийн оролцоот хангах	Хариуцах байгууллагын төсөв 200.0	хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх орон нутгийн тоо								нийслэл ийн ЭМГ	ЗДТГ, ЭМГ, олон улсын байгууллага
3.2.4 Орон нутагт эмч мэргэжилтнийг суурьшигтай урамшууллыг бий болгож нэвтрүүлэх	Орон нутгийн төсөв, Хариуцах байгууллагын төсөв	Урамшуулалд хамрагдсан эмч мэргэжилтэн, тоо	100	-	100	-	100	-	100	Аймаг, нийслэл ийн ЗДТГ, ЭМГ	Эрүүл мэндийн байгууллага, ЭМЯ, Улидаварчний эвлэл
3.2.5 Үндсэн цалинг нийлэм-эдийн засгийн зорилт, инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хариуцах байгууллагын төсөв	Сангийн яаманд хүрүүлсэн санал, дүнслт, зөвлөмж, тоо	1	-	1	-	-	-	-	ЭМЯ, СЯ	Эрүүл мэндийн байгууллагууд
3.2.6 Эрүүл мэндийн ажиглалтын нийгмийн хамгааллын чиглэлээр нэвтрүүлсэн шилдэг санаачилга, үйл ажиллагааг шалгаруулж сурталчлах, түгээн дэлгэрүүлэх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хариуцах байгууллагын төсөв 200.0	Шилдэг арга барил, санаачилга, тоо	3	50.0	3	50.0	3	50.0	3	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
3.2.7 Эрүүл мэндийн ажиглалтыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хангалтанд авах, эмчлэн эрүүлжүүлэх журмыг батлан, эрүүл мэндийн байгууллага бүр хэрэгжүүлэх	Орон нутгийн төсөв, Хариуцах байгууллагын төсөв 200.0	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмч ажигтан, тоо	200	50.0	200	50.0	200	50.0	200	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
3.2.8 Эрүүл мэндийн ажиглалтыг нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиглах	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хариуцах байгууллагын төсөв 200.0	Мэдээлэл, сурталч сурталчилгаа, тоо	10	50.0	10	50.0	10	50.0	10	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
Үйл ажиллагааны чиглэл 3.3 Эрүүл мэндийн ажиглалтыг ажлын гүйцэтгэл, урамшууллыг үйлдүүлэх удирдлагын тогтолцоот хөгжүүлэх											
3.3.1 Эрүүл мэндийн ажиглалтыг ур чадварын үнэлгээний журмыг батлуулж хэрэгжүүлэх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хариуцах байгууллагын төсөв	Урамшуулалд хамрагдсан эрүүл мэндийн ажиглалтын тоо	100	-	100	-	100	-	100	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллага, ТАЗ, ТБ, Улидаварчний эвлэл
3.3.2 Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хариуцах байгууллагын төсөв 1,000.0	Хөтөлбөр хэрэгжүүлсэн эрүүл мэндийн байгууллага, тоо	10	20	500.0	20	500.0	20	500.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд

Зорилт 4. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хандлагыг сайжруулах

Үйл ажиллагааны чиглэл 4.1 Эмч мэргэжилтний ёс зүйг төлөвшүүлж, хариуцлага, харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах

4.1.1 Анагаахын сургуульд элсэгчдэд тавигдах ёс зүй, харилцаа хандлагын шалгуурыг боловсруулж, хэрэгжүүлэх	Улсын төсөв Гадаадын зээл тусламж	Хэрэгжилт, хувь	-	30	-	50	-	70	-	100	-	ЭМЯ, ЭМХТ	БЯ, Мэргэжлийн нийслэл, холобо, ТББ, эрүүл мэндийн байгууллагууд
4.1.2 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо, дэд хорооны ажиллах эрх зүйн орчинг тодорхой болгох, санхүүжилтийг шийдвэрлэх	Улсын төсөв	Боловсруулах журал, тоо	ЭМС-ын 2017 оны А/256 тушаал	1	-	-	-	-	-	-	-	ЭМЯ	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо
4.1.3 Эмч мэргэжилтнүүдэд "Эвэлгөн ур чадвар"-ын чиглэлээр тасралтгүй мэргэжлийн боловсрол, сургалтыг зохион байгуулах	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж 500.0	Хамрагдсан эмч Мэргэжилтэн, 100	-	300	1,25.0	300	1,25.0	300	1,25.0	300	1,25.0	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд
4.1.4 Төгсөлтийн өмнөх ба дараах сургалтын хөтөлбөрт эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлагыг эзэмшүүлэх хичээлийн цаг, агуулгыг нэмэгдүүлэх	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж 500.0	Нэмж орсон агуулга, хувиар	-	20	125.0	30	125.0	40	125.0	50	125.0	ЭМЯ, ЭМХТ	БЯ, Мэргэжлийн нийслэл, холобо, ТББ, эрүүл мэндийн байгууллагууд
4.1.5 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлага, харилцаа хандлагын асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах	Улсын төсөв 40.0	Зохион байгуулагдсан арга хэмжээний тоо	-	1	20.0	-	-	1	20.0	-	-	ЭМЯ, ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлги йн мэргэ жилтний ёс зүйн хянал тын хороо	Мэргэжлийн нийслэл, холобо, ТББ, эрүүл мэндийн байгууллагууд
4.1.6 Эрүүл мэндийн ажилтан болон олон нийтэд чиглэсэн мэргэжлийн ёс зүй болон зан үйл, харилцаа хандлагыг өөрчлөх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Гадаадын зээл тусламж	Эрүүл мэндийн ажилтан Чиглэсэн арга хэмжээ, тоогоор Хамрагдсан эмч мэргэжилтэн, тоогоор Иргэдэд чиглэсэн арга хэмжээ, тоогоор Хамрагдсан иргэд, тоогоор	-	10	50.0	10	50.0	10	50.0	10	50	ЭМЯ, аймаг, нийслэл ийн ЭМГ	Эрүүл мэндийн байгууллагууд, ТББ, Мэргэжлийн холобо

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 4379 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨРГЖИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГРЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Хүрэх түвшин				Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
			түвшин	он	2025 он	2026 он	2027 он	2028 он		
Зорилт 1. Эрүүл мэндийн ажилтан бэлтгэх тогтолцоог эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хэрэгцээтэй уялдуулах										
1.	10,000 хүн амд ногдох эмчийн тоо	тоо	44.3	2024	46.0	47.0	48.0	49.0	Жилд нэг удаа	ЭМХТ
2.	10,000 хүн амд ногдох сувилагчийн тоо	тоо	42.8	2024	45.0	46.0	47.0	48.0	Жилд нэг удаа	ЭМХТ
3.	Магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр	тоо	35	2024	38	42	46	50	Жилд нэг удаа	Боловсролын яамны статистик мэдээ
4.	Бэлтгэгдсэн сувилагч, туслах сувилагч	тоо	580	2023	650	750	750	750	Жилд нэг удаа	Боловсролын яамны статистик мэдээ
Зорилт 2. Эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх										
5.	Гадаад улсад урт, богино хугацааны сургалтад багаар хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн	Суралцсан баг, тоо	-	-	12	5	5	5	Жилд нэг удаа	ЭМХТ
6.	Ерөнхий мэргэшлийн сургалт эрхлэх байгууллага	СЭБ-ын тоо	14	2024	18	20	22	24	Жилд нэг удаа	ЭМХТ
7.	Монгол Улсад ажилласан гадаадын нэр хүнд бүхий эмч мэргэжилтэн	Зочин профессор, тоо	25	2024	30	50	60	70	Жилд нэг удаа	Тайлан мэдээ
Зорилт 3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах дэмжлэгт орчин сайжруулах										
8.	Орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан Эрүүл мэндийн ажилтан	хувь	16	2024	≥20	≥25	≥30	≥35	Жилд нэг удаа	Судалгаа
9.	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааны хөтөлбөр хэрэгжүүлсэн ЭМБ	хувь	-	-	≥15	≥25	≥40	≥60	Жилд нэг удаа	Тайлан мэдээ
Зорилт 4. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хандлагыг сайжруулах										
10	Ёс зүйн сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн	хувь	60	2024	100	100	100	100	Жилд нэг удаа	Тайлан мэдээ